

## ОРОСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ВЛАДИМИР ПУТИНЫ ОЛОН ТУЛГУУРТ ГАДААД БОДЛОГЫН ТУХАЙ

*Д.Эрдэнэ-Отгон\**

Шинжлэх ухаан техникийн шинэ хувьсгал гарч маш хурднаар өргөжин хөгжиж буй өнөө үед дэлхий дээр цэрэг зэвсгийн шинэчлэл хурдсаж, хүрээ хэмжээ нь тал бүрээр тэлэн өргөжиж байна. Энэ нь хүн төрөлхтний түүхэн дэхь аливаа үеийн цэрэг зэвсгийн шинэчлэлтэй зүйрлэхийн аргагүй юм. Ялангуяа, өнөө үед агаарын цэргийн хүчин чадлаар аливаа дайны гол асуудлыг шийдвэрлэх болж байна. Энэ бол зэвсэг техник хөгжсөн том гүрнүүдийн ноёрхол тогтно гэсэн үг. Эдүгээ ийм байдал ч энд тэнд мэр сэр үзэгдсээр байна.

XX зуунд Орос гүрэн /хуучнаар ЗХУ/ дэлхийн байдлыг тэнцвэржүүлэхэд, түрэмгий дайныг хазаарлан зогсооход нэн чухал үүрэг гүйцэтгэж байсан. Гэвч 1980-аад оны сүүлчээр ЗХУ задарч, ардчилалын давалгаа үүсч, нэгдмэл байдал нь алдагдаж, эдийн засгийн хүчин чадал нь сүрхий доройтсон юм. Ингэж задарч бутарч хүчин чадал нь суларсан нь дотроосоо шалтгаалснаас гадна Америк болон Өрнөдийн улсуудын шахалт хавчлага их нөлөөлсөн байна.

Ер нь 2000 оноос хойш дотоодын хүнд байдлаас гадна Орос улсыг Америк, Өрнөдийн орнууд улам их дарамтлах байдалтай байв. Тэгвэл тийм байдлаас яаж гарах ёстой юм. Хүчээр биш, бусдын эрхшээлд орох байдлаар биш, урагшгүй муу үйл ажиллагаагаар биш, гагцхүү Оросын өмнөх түүхийн хуудсыг сөхөн харж хүч дорой байсан ч, хавчлага их байсан ч, цаг үе хүнд байсан ч орос хүн нэг шүд зуун босч урагшилбал ямар хүч болдогийг санаж ухаалаг бодлого явуулах явдал байсан юм. Ийм байдлын дундаас В.Путин гарч ирж Оросын ерөнхийлөгч болсон билээ.

В.Путин Оросын ерөнхийлөгч болсны дараа улс орныхоо дотоод байдлыг улс төр, эдийн засгийн хувьд өөд татахын тул уйгагүй шургуу ажиллаж богино хугацаанд амжилт олов. В.Путин Орос улсын гадаад байдлыг тэнцвэржүүлж тогтвортой байлгахын тул “Олон тулгуурт гадаад бодлого” явуулж богино хугацаанд амжилт олж байна. Ялангуяа, 2002 оноос түүний энэ бодлого үзэгдэхүйц амжилт олж байна. 2002 он бол В.Путины эрх барьсан гурав дахь жил юм.

Олон тулгуурт гадаад бодлого гэдэг бол улсынхаа гадаад харилцааны нэр хүндийг өргөхөөс гадна бас улсынхаа эдийн засгийг өөд

\*Д.Эрдэнэ-Отгон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

татан тогтворжуулахад ач тустай юм. В.Путины олон тулгуурт бодлогын хүрээнд, юуны урьд Орос-Америкийн харилцааг сэргэлдөөнөөс гаргах, мөн Өрнөдийн орнуудтай харилцаагаа сайжруулж найдвартай, бодитой, эрх тэгш харилцаа тогтоох; дэлхийн бөмбөрцгийн хэмжээний гадаад бодлого явуулах, гэхдээ дэлхийн том гүрэн гэдэг үүднээс эдгээр бодлогоо явуулж Европ, Ази, Африк, Латин Америкийн зэрэг тив дэлхийн улсаар найдвартай шинэ холбоотон эрэх, улсын их багыг ялгахгүй бүгдтэй нь нөхөрлөх явдал юм.

В.Путины эдүгээгийн үйл ажиллагаанаас харвал тэрээр авьяаслаг зохион байгуулагч болох нь харагдаж байна. Орос оронд ийм удирдагч үнэхээр хэрэгтэй. Түүгээр ч барахгүй Монгол улсад ч нөөлөг нөмөртэй удирдах хүн мөн гэж өчүүхэн судлаач би үзэж байна.

Одоо В.Путины олон тулгуурт гадаад бодлого хэрхэн хэрэгжиж байгааг товчхон авч үзье.

ОХУ, АНУ-ын харилцаа эерэг талаараа идэвхижих нь олон улсын байдлыг хэвийн болгож сайжруулахад гол хүчин зүйл болох юм. Цөмийн зэвсэгтэй дэлхийн хоёр том гүрэн ОХУ, АНУ-ын харилцаа өргөжин сайжрах нь дэлхийн улс түмний эрх ашигт бүрэн нийцэж, энэ хоёр том гүрний алхах гишгэх нь хүртэл ямагт бүхний анхаарлыг татаж байдаг. Олон арван жил нөхөрлөн ач тусыг нь хүртсэн Монголын ард түмэн хойд их хөршийнхөө төр засгийн явуулж буй бодлогыг цаг ямагт анхааран харж ажил үйлс, сэтгэл санаагаараа үргэлж дэмжиж байдаг билээ. Өөрөөр хэлбэл, ОХУ, АНУ хоёрын харилцаа сайжрах нь Монгол улсын гадаад орчинд нэн тааламжтай нөхцөл бий болох юм.

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин, АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буш нар Санкт-Петербургт уулзаж, хоёр талын харилцааг хөгжүүлэх, алан хядах ажиллагааны эсрэг хамтран тэмцэх, Орос, НАТО-гийн хамтын ажиллагаа болон олон улсын тулгамдсан асуудлаар санал солилцлоо. В.Путин өргөжин тэлж буй НАТО-гийн үйл ажиллагаа ОХУ-ын үндэсний ашиг сонирхолд нийцэж байвал Москва харилцаагаа хөгжүүлэх боломжийг үгүйсгэхгүй гэж мэдэгдэв. Ж.Буш Прагад болсон НАТО-гийн дээд хэмжээний уулзалт дээр “Орос бол дайсан биш, харин нөхөр” гэж мэдэгдсэн нь чухал үйл явдал боллоо гэж тэмдэглэв.

Бид терроризмын эсрэг глобал дайнд Орос улстай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна хэмээн АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид дурдсан байна. Сүүлийн үеийн бүх уулзалт, ярилцлагууд дээр терроризмын эсрэг дайныг хоёр тал дэмжиж байгаагаа үргэлж илэрхийлсээр байна. АНУ хуучин ЗХУ-ын харьяанд байсан Төв

Азийн бүс нутагт Афганистаны дайны үеэр цэргийн хүч оруулахыг эсэргүүцээгүй нь АНУ-ын байр суурийг ОХУ-д ашигтайгаар эргүүлсэн бололтой.

Одоогийн байдлаар Чеченд болж байгаа хэрэг явдлыг АНУ хүний эрхийн үүднээс шүүмжлэхээ нэгэнт больсон бөгөөд Орос улс Чечений хямралыг олон улсын терроризмын нэг хэсэг гэдгийг Америкаар хүлээн зөвшөөрүүлж чадлаа.

Харин Иракийн асуудлаар ОХУ, АНУ-ын удирдагчид зөрөөтэй байр суурьтай байв. Саяхан АНУ-Иракийн дайн эхэлмэгц зөрөөтэй байр суурь нь хурцдах шинжтэй болж эхлэв. Гэхдээ Иракийн дайны талаар зарчмын бөгөөд уян хатан бодлого баримтлав. Түүний Иракийн талаар баримталсан бодлогыг Франц, Германы удирдагчид дэмжиж Иракийн асуудлыг шийдвэрлэхэд НҮБ гол үүрэг гүйцэтгэнэ гэдэг байр суурийг хатуу баримталж байв. Ийнхүү В.Путин олон улсын байдлаар ухаалаг бодлого явуулдаг удирдагч болох нь Иракийн дайны үед бас л тод харагдсан.

Орос улс Умард Атлантын эвсэлтэй /НАТО/ шинэ холбоо тогтоож эхлэв. 2002 оны 5-р сард Орос улс Умард Атлантын эвсэлтэй “Ромын тунхаг” гэдэг баримт бичигт гарын үсэг зурав. Тэгснээр уг эвсэл холбоо нь 19+1 болж 20 улс болов. Дараа нь 2002 оны 2-р сард Умард Атлантын эвсэлтэй сөргөлдөхгүйгээр харилцаж зарим талаар хамтран ажиллах болсон байна. Гэхдээ яг тэр байгууллагын гишүүн орон биш болох нь тодорхой юм. Энэ эвсэл уг нь Зөвлөлтийн эсрэг л чиглэж гарч ирсэн цэргийн эвсэл юм. Өнөө үед ийм эвсэлтэй сөргөлдөх биш, эвтэй баймааж улс орныхоо дотоод, гадаад байдлыг бэхжүүлэх гэсэн ерөнхийлөгч В.Путины бодлого даруй мөн юм.

Орос-Европын холбооны харилцаа сүүлийн үед мэдэгдэхүйц сайжирч байна. 2002 онд Орос, Европын холбоотой хоёр удаа дээд хэмжээний уулзалт хийж нэлээд үр дүнтэй болов. 2002 оны 11-р сард Орос, Европын холбоо уулзан Калининградын асуудлаар тохиролцон гарын үсэг зурав. Энэ нь бас л олны сонирхлыг татсан нааштай асуудал болсон юм. В.Путин ерөнхийлөгч 2002 оны сүүлчээр Европын хэд хэдэн орноор зочлов. Ялангуяа Герман, Франц улсад зочлох үед Германы канцляр Шрёдер, Францын ерөнхийлөгч Жак Ширак нартай дотно харилцаа тогтоож дэлхий дахины чанартай асуудлууд, ялангуяа Иракийн дайны асуудлаар нэг байр суурь баримталсгаав. Чухам ингэж Орос улс Өрнөдийн гол гол улс оронтой харилцаагаа сайжруулан ойртож байгаа хэдий ч НАТО өргөжин тэлж Оросын хилд ойртож буйд болон пуужин

эсэргүүцэх төхөөрөмжийн талаар өөрийн гэсэн бодлого, байр сууриа хадгалсаар байна.

Орос улс ТТУХН-ийн улсуудтай шинэ маягийн харилцаа тогтоож байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн нөхцөл байдалд тохируулан уламжлалт харилцаагаа сэргээн барих явдал юм. Сүүлийн үед Америк улс ТТУХН орнууд дотор идэвхитэй ажиллагаа явуулж өөртөө татахыг хичээн оролдож ирэв. Энэ нь Орос улсын сэтгэлийг түтшүүлж эхэлсэн байна. Иймээс В.Путин ТТУХН-ийн орнуудын ялангуяа Ази талын улсуудын аюулгүй байдлыг урьдын адил хамтын хүчээр сахин хамгаалах гэрээ байгуулах, Оросын Батлан хамгаалах Яамны Жанжин штабын даргаар удирдуулсан цэргийн нэгдсэн хүчин байгуулах ажлыг хийж байна. Киргиз улсад цэргийн нэгдсэн хүчний төв бааз байгуулж нэгдсэн цэргийн хээрийн сургууль хүртэл хийж байна.

Орос улс Гүрж, Азербайжантай харилцаагаа хэвийн болгохын тулд бас л ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Сүүлийн үед Гүрж улс нутаг дэвсгэртээ Америкийн цэргийн бааз байгуулж болох тухай, НАТО-д гишүүнээр элсэх тухай хэлэлцээ хийж эхлэв. Мөн Орос, Гүржийн хилийн будлиан нэлээд их байгаагаас хоёр улсын харилцаа сайн биш байгаа. Эдгээрийг гэтлэн давахын тул В.Путин бас л их санаачлага гаргаж уян хатан бодлого баримталж байна. Харин Азербайжантай харилцаагаа сайжруулж байна. Үүний нэгэн илрэл нь Азербайжаны ерөнхийлөгч Алеев Москвад зочилж эдийн засгийн талаар хамтран ажиллах гэрээ байгуулсан явдал юм. Орос, Украйны харилцаа сүүлийн үед их идэвхижиж байна. Нэг хэсэгтээ Украйны ерөнхийлөгч Кучмагийн байр суурь дотооддоо тогтвортой биш байдалтай болж эхэлсэн байв. Ийм үед В.Путин Кучматай 6 удаа хэлэлцээ хийж түүний бодлогыг шууд дэмжихээ илэрхийлэв. Саяхан ерөнхийлөгч Кучма Орос улстай харилцах нь Украйны гадаад бодлогын үндэс суурь мөн гэж хэлэв. Кучма ерөнхийлөгч 2003 оны 3-р сард манай Монгол улсад зочлов.

Орос, Беларуссын харилцаа хэвийн сайн байж, олон талаар хамтран ажиллаж байна. Беларуссын талаас ТТУХН-ын орнууд ойртон нягтарч дотно харилцаа тогтоохыг санаачилж байдаг юм.

Дээрхи үйл явдал бол В.Путины олон тулгуурт гадаад бодлогын үр дүн мөн юм. Ер нь аливаа зүйлийг хүчээр биш ухаанаар шийдвэл илүү амжилт олно гэдгийг чухал энэ буюу.

Владимир Путин Хятад, Энэтхэгтэй харилцаагаа сайжруулж гар нийлсэн холбоотон улс болж байна. БНХАУ-тай харилцаагаа бүх талаар сайжруулахыг В.Путин гадаад харилцааныхаа тэргүүн зорилт

болгов. Энэ бодлогыг хятадын тал ч бүх талаар дэмжив. В.Путин 2000 оны 7-р сарын 17-19-нд БНХАУ-д зочилж хилийн асуудал, худалдаа, эдийн засгийн асуудал, Шанхайн уулзалт зэрэг олон асуудлаар харилцан ашигтай тохиролцоо хийсэн байна. 2002 онд БНХАУ-ын дарга Зянь Зэмин Орос улсад зочлов. Энэхүү зочлолт туйлын амжилттай болсон байна. Хоёр улсын удирдагчид Москвад “Орос-Хятадын сайн хөршийн хамтран ажиллах найрамдлын гэрээ”-нд гарын үсэг зурсан юм. 2002 оны 12-р сарын 1-3-нд В.Путин ерөнхийлөгч хоёр дахь удаагаа БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Өндөр хэмжээнд болсон энэ айлчлал үр дүнтэй боллоо гэж хоёр талын хэвлэл мэдээллээр дүгнэж ярих. 12-р сарын 2-нд БНХАУ-ын дарга Зянь Зэмин, ХКН-ын дарга Ху Зиньгао, Ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны дарга Ли Пэн, Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Чжу Рунжи нар тус тус хүлээн авч уулзаад хоёр улсын хамтын ажиллагааны талаар туйлын ашигтай яриа хэлэлцээ өрнүүлэв. Зянь Зэмин ярьсан нь: “Сүүлийн 10 жилийн дотор хоёр улсын харилцаа маш хурдан амжилттайгаар хөгжсөн нь улс төрийн өндөр хэмжээнд харилцан итгэлцэх эх суурийг тавьж өглөө. Хоёр улс үеийн үед эв найрамдалтай байх болно” гэжээ. Энэ тухай 2002 оны 12-р сарын 3-ны “Жэньминь жибао”-д тодорхой бичжээ. 2002 оны 12-р сарын 1-3 хүртэл Оросын хэвлэл, радио телевизээр В.Путины Хятадад хийсэн айлчлалын талаар маш өргөн сурталчлав. Тухайлбал, ИТАР-ТАСС-ийн мэдээгээр В.Путин БНХАУ-д зочилсон нь Орос-Хятадын харилцааны хоорондын итгэлцлийг улам ихээр гэрэлтүүлэн хөгжүүлэв гэх мэтээр нэвтрүүлж байв. Мөн Оросын хэвлэлүүд Орос-Хятадын удирдагчид Орос-Хятадын сайн хөршийн хамтран ажиллах найрамдлын гэрээнд гарын үсэг зурсан нь найрамдалт харилцааны чигийг зааж өгөв гэж бичиж байв.

2002 оны 1-10 сард хоёр улсын худалдааны эргэлт 120 миллиард доллар болсон нь хоёр улсын түүхэнд шинэ эргэлт болсон ажээ. В.Путин “Жэньминь жибао” сонины сурвалжлагчидтай уулзаж Орос-Хятадын харилцаа өндөр хэмжээнд хөгжиж байгааг үнэлэн яриад БНХАУ-ын эдийн засгийн хурдан хөгжлийг үнэн мөнөөр дүгнэжээ.

Орос-Энэтхэгийн уламжлалт харилцаа улам өргөжиж хоёр улсын эрчим хүч ашиглах болон гадаад худалдаа их өргөжив.

Орос улс Умард Солонгостой уламжлалт харилцаагаа хэвийн болгож Ким Чен Ир-ийг урьж зочлуулаад төмөр замын тээврийн зэрэг салбарт хамтран ажиллах болсон байна. Энэ бол хоёр Солонгосын талаар баримталж буй нааштай ажиллагаа мөн гэж үзэлтэй.

Мөн Латин Америк, Африкийн улс орнуудтай харилцаагаа идэвхижүүлж байна.

Эцэст нь, Оросын Ерөнхийлөгч Владимир Путины олон тулгуурт гадаад бодлого улам бүр амжилт олж байгаагийн баталгааг дээрхи үйл явдлаас харж болох ажээ.